

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН “ТАЛХ ЧИХЭР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД ТАНАА

Санхүүгийн тайлангийн Аудитын тайлан

Дүгнэлт

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тодруулгаас бүрдсэн “Талх чихэр” ХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Талх чихэр” ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд, Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуух үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн ба асуудлуудын улмаас дүгнэлтээ хязгаарлаагүй.

Аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно.

Татварын тооцоолол, үнэн зөв байдал

- Татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учир бид татварын багц хуулийн хэрэгжилтийг эрх бүхий байгууллага шалгаж хүү, торгууль, алданги, нөхөн татвар тавигдах эрсдэл байгааг тооцон татварын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзлээ. Бид өөрсдийн үнэлэмж тооцоолол, олж авсан мэдлэг, нотлох баримтдаа үндэслэн үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч эрсдэл байсаар байгаа.

Бидний гүйцэтгэсэн горим, сорил :

- Татварын тооцоолол болон түүнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлого, татварын талаарх засаглах удирдлагын байр суурь үнэлгээг судлах, санхүүгийн тайланд бүртгэгдсэн татварын тооцооллын үнэн зөвийг үнэлэх, татварын цахим системтэй тулган баталгаажуулах горим сорилыг гүйцэтгэсэн.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Хэрэв бид аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээлэлд хийсэн өөрсдийн ажилд үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухайгаа тайлагнах шаардлагатай. Үүний дагуу тайлагнах зүйл бидэнд байхгүй болно.

Компанийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага компанийн санхүүгийн тайланг гаргах болон үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах чадамжтай байх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан гэсэн үг үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг тайланг бэлтгэлээ.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн

Гүйцэтгэх захирал



Ч.Эрдэнэжав

Огноо: 2025 оны 04 дугаар сарын 16 өдөр

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛГОСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ХУРААНГУЙ ҮЗҮҮЛЭЛТ**

Талх Чихэр ХК
(Байгууллагын нэр)

	/төгрөг/	
ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
А.ХӨРӨНГӨ		
1. Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	97,531,269.70	5,099,664,630.67
Дансны авлага	6,310,345,571.31	6,705,847,623.97
Татвар, НДШ-ийн авлага	10,619,437.76	29,532,233.10
Бусад авлага	-	-
Бараа материал	7,696,962,215.16	14,105,477,713.92
Урьдчилж төлсөн зардал /тооцоо	13,061,586,532.24	10,560,259,975.93
Эргэлтийн хөрөнгийн дүн	27,177,045,026.17	36,500,782,177.59
2. Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	60,612,664,624.43	70,501,494,104.78
Биет бус хөрөнгө	-	-
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	60,612,664,624.43	70,501,494,104.78
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	87,789,709,650.60	107,002,276,282.37
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
3. Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	9,550,822,425.10	8,868,960,284.79
Цалингийн өглөг	1,122,806,749.00	1,196,593,320.23
Татварын өр	1,035,145,497.22	1,710,489,163.91
Ногдол ашгийн өглөг	1,975,851,098.53	2,310,071,543.20
Урьдчилж орсон орлого	-	-
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	753,078,108.14	868,090,440.59
Богино хугацаат өр төлбөрийн дүн	14,437,703,877.99	14,954,204,752.72
4. Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	1,069,701,180.77	11,306,288,059.84
Нөөц /өр төлбөр/	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	829,489,223.50	829,489,223.50
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,899,190,404.27	12,135,777,283.34
Өр төлбөрийн нийт дүн	16,336,894,282.26	27,089,982,036.06
5. Эзэмшигчийн өмч		
Өмч:		
- төрийн		
- хувийн		
- хувьцаат	102,370,300.00	102,370,300.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,340,772,092.32	23,340,772,092.32
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	48,009,672,976.02	56,469,151,853.99
Эздийн өмчийн дүн	71,452,815,368.34	79,912,294,246.31
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	87,789,709,650.60	107,002,276,282.37



ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Цэвэр борлуулалт	122,329,182,510.74	128,901,287,181.54
Борлуулалтын өртөг	85,702,890,758.72	96,564,481,185.81
Нийт ашиг (алдагдал)	36,626,291,752.02	32,336,805,995.73
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	26,353,223,201.66	21,665,678,313.14
Санхүүгийн зардал	-	509,529,110.24
Бусад зардал	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз(гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	(613,604,311.65)	(61,720,984.07)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	9,659,464,238.71	10,099,877,588.28
Орлогын албан татварын зардал	1,668,267,137.59	1,640,399,643.09
(алдагдал)	7,991,197,101.12	8,459,477,945.19
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	7,991,197,101.12	8,459,477,945.19
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Орлогын нийт дүн	7,991,197,101.12	8,459,477,945.19
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Өмч	102,370,300.00	102,370,300.00
Халаасны хувьцаа	-	-
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	23,340,772,092.32	23,340,772,092.32
Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг /- алдагдал/	48,009,672,976.02	56,469,151,853.99
Нийт дүн	71,452,815,368.34	79,912,294,246.31



МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	139,311,306,470.83	125,445,813,474.66
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	139,311,306,470.83	125,445,813,474.66
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	132,354,355,623.09	130,491,695,034.74
Ажиллагчдад төлсөн	16,047,177,007.83	17,076,237,912.27
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,372,550,036.51	5,458,717,140.81
Бараа материал худалдан авахад төлсөн	106,675,671,672.76	97,264,843,058.80
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Хүүний төлбөрт төлсөн	128,530,355.49	509,529,110.24
Татварын байгууллагад төлсөн	1,804,447,619.97	1,653,209,926.85
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	2,325,978,930.53	8,529,157,885.77
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,956,950,847.74	(5,045,881,560.08)

2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	-	6,254,387.01
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	6,254,387.01
Мөнгөн зарлагын дүн (-)	5,882,022,646.50	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,882,022,646.50	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,882,022,646.50)	6,254,387.01

3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн (+)	1,485,620,209.60	13,290,498,883.63
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,465,345,709.60	13,244,958,064.72
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	20,274,500.00	45,540,818.91
Бусад	-	-
Мөнгөн зарлагын дүн (-)	2,649,042,864.03	3,133,520,542.96
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,643,754,901.33	3,065,785,863.16
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
Төлсөн ногдол ашиг	5,287,962.70	67,734,679.80
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,163,422,654.43)	10,156,978,340.67
Валютын ханшийн зөрүү	(3,533,250.26)	(115,217,806.63)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(92,027,703.45)	5,002,133,360.97
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	189,558,973.15	97,531,269.70
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	97,531,269.70	5,099,664,630.67

